



УЛААНБААТАР ЛИФТ НӨҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Г Албан хаагчид ур чадварын нэмэгдэл Г
олгох журам батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Улаанбаатар лифт” Нийслэлийн Өмчит Үйлдвэрийн газрын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар лифт” Нийслэлийн Өмчит Үйлдвэрийн газрын албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий инженер /М.Энхбат/-т үүрэг болгосугай.


ДАРГА



Д.ГАН-ЭРДЭНЭ

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын даргын
2022 оны 01 сарын 03-ний өдрийн
А/оу тоот тушаалын хавсралт

АЛБАН ХААГЧИД УР ЧАДВАРЫН
НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, Төсвийн Ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, байгууллагын дүрмээр хүлээсэн үүрэг болон байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, албан хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, ажлыг үр дүнг бодитой үнэлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад оршино.

Хоёр. Ажилтан, албан хаагчийн ажил дүгнэх

2.1 Нэгжийн дарга нар ажилтан албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг тооцон олгохдоо шударга, ил тод зарчмыг баримтлан сар бүрийн 20-ны дотор дүгнэнэ.

2.2 Ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 10-25 хувиар тооцож олгоно.

2.3 Нэгжийн дарга нарын болон ажилтнуудыг дүгнэсэн үнэлгээг Хүний нөөцийн мэргэжилтэн нэгтгэж газрын даргад танилцуулан баталгаажуулна.

Гурав. Ур чадварын нэмэгдэл олгох

3.1 Эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд гүйцэтгэж байгууллагын зорилго, зорилтыг биелүүлэхэд идэвх санаачилага гаргаж, өгсөн үүрэг даалгаврыг хугацаандаа биелүүлсэн, багаар ажиллах чадвар, өөрийгөө тасралтгүй хөгжүүлсэн байдал, олон нийтийн ажлын оролцоо зэргийг харгалзан ур чадварын нэмэгдлийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж олгоно.

Ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийн хүснэгт

Д/д	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо	Хувь
1	Төлөвлөгөөт ажлын биелэлт	50 оноо	12,5%
2	Үүрэг даалгаварын биелэлт	10 оноо	2,5%
3	Олон нийтийн ажилд оролцсон байдал	20 оноо	5%
4	Ажлын цаг ашиглалт	10 оноо	2,5%
5	Тогтоол шийдвэр, албан бичиг, иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлт	5 оноо	1,25%
6	Мэдлэг боловсрол, өөрийгөө хөгжүүлсэн байдал	5 оноо	1,25%
	Нийт	100 оноо	25%

3.2 Ур чадварын нэмэгдлийг зөвхөн тухайн албан тушаалыг эрхэлж буй хугацаанд, ажилласан өдөрт ногдох цалингаас тооцож сар тутам олгож болно.

3.3 Ажилтан тухайн сарын ажлын хоногийн 70%-д бүтэн ажилласан тохиолдолд ур чадварын нэмэгдэл олгогдох эрх үүснэ.

Дөрөв. Ур чадварын нэмэгдэл олгохгүй байх үндэслэл

4.1. Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан бол шийтгэлтэй байх хугацаанд.

4.2. Ээлжийн амралт нь 2 сар үргэлжилсэн бол аль олон хоног амарч байгаа сарын.

4.3. Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлээгүй тохиолдолд.

4.4 Туршилтын болон түр хугацаагаар ажиллаж байгаа ажилтанд.

4.5 Тухайн сард ажлын байранд хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн зөрчил гаргасан, тус газрын “Ёс зүйн дүрэм”-г зөрчсөн тохиолдолд.

Тав. Мөрдөж эхлэх хугацаа

5.1 Энэхүү журмыг Газрын дарга баталсан өдрөөс эхлэн мөрдөнө.